"БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ"ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2010 оны 02 дугаар сарын 12 -ны өдөр | Дугаар 33 | Багануур

Журам батлах тухай

"Багануурын дулааны станц" ТӨҮХК-ийн Жөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААЖ ІНЬ:

Нэг. "Багануурын дулааны станц" ТӨҮХК-д ашиглагдаж буй "Химийн хорт болон аюултай бодисыг ашиглах журам"-ыг хавсралтаар батлагдсугай.

Хоёр. Дээрх журмыг 2010 оны 02-р сарын 18-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг химийн инженер С. Онөөнчимэгт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш.БАЯНМӨНХ

"БНДС" ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2010 оны 02-р сарын 12-ны өдрийн 33 тоот тушаалын хавсралт

"Багануурын Дулааны Станц" ТӨХК-д ашиглагдаж буй Химийн хорт болон аюултай бодисыг ашиглах журам

Нэг.Зорилго

1.1."Химийн хорт болон аюултай бодисын тухай" Монгол Улсын хуулийн заалтуудыг мөрдөх

1.2.Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, ашиглах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаанд тавих үндсэн шаардлагыг хэрэгжүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

Хоёр.Химийн хорт болон аюултай бодисыг хадгалахад тавих шаардлага

2.1.Химийн хорт болон аюултай бодис хадгалах агуулахыг хүн олноор байрлах, гал гарч болзошгүй болон халаалтын эх үүсвэрээс хол газар, шууд нарны гэрэл тусахааргүй нөхцөлд хадгалах .

2.2.Химийн хорт болон аюултай бодисыг агуулахад хадгалахдаа "Химийн хорт болон аюултай бодисын тухай" Монгол Улсын хуулийн заалтын дагуу бодисын шинж чанар, орчинд болон бие биедээ нөлөөлөх нөлөөллөөс нь хамааруулан тус тусад нь хадгалж байх.

2.3.Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах агуулахыг болон шинжилгээний лабораторуудыг агааржуулалтын системтэй байлгах.

2.4.Хадгалахдаа хүний нүдний түвшингээс дээгүүр түвшинд байрлах тавиур дээр байрлуулахгүй, химийн бодисын тавиур нь гулсаж унахаас хамгаалсан хаалт саадтай байх, хэрэв химийн бодисыг шалан дээр хураах хадгалах үедээ хүн явах зам гарган байрлуулах ба гарцыг хаахгүй байх.

2.5.Шингэн химийн бодисыг хагардаггүй, эсвэл бат бэх хагардаггүй давхар савалгаатай саванд хадгалах, агуулахын температур нь тухайн бодисын хадгалах нөхцөлд тохирсон байх.

2.6.Химийн бодисын агуулахад асгарч гоожсон эсвэл эвдэрхий сав баглаа боодолтой химийн бодис хадгалахыг хориглоно.

2.7.Химийн агуулахад ил гаргах, шүдэнз зурахыг хориглоно.

2.8.Химийн хорт болон аюултай бодисыг ууллэх, савнаас нь хэсэгчлэн авахдаа салхивч, агааржуулалтын систем хэрэглэн гүйцэтгэнэ.

2.9.Агуулахад хадгалж буй химийн бодисын хор, аюулын шинж чанараас хамааруулан зохих анхааруулах тэмдэг, дохио, үг,аюулын тухай тэмдэглэгээг агуулахын гадна болон харагдахуйц байрлалд тодоор зурж бичиж байрлуулах.

2.10.Химийн бодисын агуулах нь гадны хүн үл нэвтрэх хаалт, цоожтой байх ба зөвхөн хариуцагч этгээдийн хувийн тэмдэг бүхий лацаар битүүмжлэгдсэн байх.

2.11.Агуулах нь хадгалж буй бодисын ангилал, нэр төрөл, тоо хэмжээг тусгасан байнгын бүртгэлтэй байх.

2.12.Химийн бодисын агуулахад хүнсний зүйл хадгалах, хэрэглэхийг хориглоно.

Гурав.Химийн хортой болон аюултай бодисыг тээвэрлэхэд тавих шаардлага

3.1.Химийн хорт болон аюултай бодистой бараа бүтээгдэхүүнийг зөөж тээвэрлэхдээ зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх бөгөөд зөвхөн тогтоосон маршрутын дагуу тээвэрлэлтийн шаардлага хангасан сав баглаа боодолтой хагарч асгарч гэмтэхээргүй зөөлөвч, жийрэгтэйгээр, нийтэд сэрэмжлүүлсэн таних тэмдэг, анхааруулсан тод бичигтэйгээр зөөвөрлөх бөгөөд хүнсний зүйл, бусад харшлах ачаатай болон хүн, мал, амьтантай хамт тээвэрлэхийг хатуу хориглоно.

3.2.Химийн хорт болон аюултай бодисын тээвэрлэлтийн үед ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдохоос урьдчилан сэргийлж тэдгээрийг зөв байрлуулан зөөж тээвэрлэж байх.

3.3.Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодол нь гэмтэлтэй, таних тэмдэг, нэр хаяггүй байвал тээвэрлэхийг хориглоно.

3.4.Хамт хадгалж болдоггүй химийн бодисыг нэг тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг хориглоно.

3.5.Химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэгч нарт тухайн бодисын хор уршгийн болон тээвэрлэлтийн явцад гарч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл анхааруулгыг албан ёсоор өгч байх.

Дөрөв.Химийн хортой болон аюултай бодисыг ашиглахад тавих шаардлага

4.1.Химийн хорт аюултай бодисыг ашиглан үйл ажиллагаа явуулах лаборатор, ажлын байр нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангасан байх.

4.2.Ашиглаж буй химийн бодисын хор, аюул, шинж чанарыг анхааруулсан анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тухай тэмдэглэгээ, хаяг шошгыг ажлын байранд болон тухайн бодисын сав, баглаа, боодол дээр харагдахуйц байрлалд тодоор зурж бичиж байрлуулсан байх.

4.3.Химийн хорт болон аюултай бодисыг ашиглах явцдаа технологийн горимыг нарийн чанд мөрдөж ажиллан, орчин дэлбэрэлт болон ажлын байраар зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн хог хаягдал гаргахгүй байх үүрэг хүлээж ажиллах.

4.4.Химийн хорт болон аюултай бодисын хаягдал, ашиглалтын хугацаа дууссан, чанарын шаардлага хангахгүй болсон бодис хольц болон сав баглаа боодлыг устгахдаа “Химийн хорт болон аюултай бодисын” тухай хуулийн заалтын дагуу гүйцэтгэж байх.

Тав. Бусад

5.1.Энэхүү журмын биелэлтэд тавих хяналтыг холбогдох удирдлагууд болон инженер техникийн ажилтнууд хэрэгжүүлж ажиллах.

5.2.Химийн хорт бодисын ашиглалт зарцуулалтын тухай дэлгэрэнгүй бүртгэл /нэр төрлөөр нь / хөтөлж устгалт, үлдэгдлийн тухай тайланг зохих шатны хүмүүст болон холбогдох газарт хүргүүлж байх.

5.3.Химийн бодисын сав баглаа боодлыг ахуйн зориулалтаар ашиглахыг хориглоно.

5.4.Мэргэжлийн хордлого осол гаргасан тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр нийгэм хамгааллын хяналтын алба, мэргэжлийн хяналтын алба, онцгой байдлын хэлтэс зэрэг газарт яаралтай мэдээлж аюулыг зайлуулах ажлыг мэргэжлийн хяналтын дор гүйцэтгүүлэх.